


Алдагдсан нэг хонь

-The Lost Sheep-



56Page

Тайлбарлагч Хүмүүс Есүсийн сургаалыг сонсохыг хүсэж байлаа. Тиймээс Есүсийн явсан газар бүрд олон хүмүүс цугладаг байв. Харин хэсэг бүлэг хүмүүс Есүст дургүйлхдэг байв.

Хүн-1 Есүс их сонин.

Хүн-2 Харин тийн, нүгэлтэй хүмүүстэй хамт байж бүр хоол цуг идсэн гээд бод доо. Тэр яавч зөв зүйл биш.

Тайлбарлагч Есүс тэдэнд хандан нэгэн сургаал үлгэр ярьж өгөв.



57Page

Тайлбарлагч Дээр үед зуун хоньтой нэгэн хоньчин амьдардаг байжээ. Тэр хоньчин, хониндоо их хайртай байлаа. Үдэш болж хонио эргүүлэх цаг болж хоньдоо тоолж эхлэв.

Хоньчин За тооллогондоо...нэг, хоёр, гурав..., хорь, гуч, дөч..., ерөн найм, ерөн ес... айн? Дутаж байх чинь, дахиад тоолноо. "нэг, хоёр, гурав...ерөн долоо, ерөн найм, ерөн ес... дахин тоолсон ч нэг хонь алга байх чинь.

Тайлбарлагч Хоньчин дахин тоолж үзсэн ч яалт ч үгүй нэг хонь дутуу байлаа.

Хоньчин Нэг хонь минь яачихваа...

Тайлбарлагч Хоньчин алга болсон нэг хониндоо санаа зовон энэ тэрүүгээр хайж эхлэв.

Тайлбарлагч Харуй бүрий болж хоньчин хонио хайж байхдаа усанд ч унаж, гуу жалганд ч бүдэрч унав. Гэсэн ч шантралгүйгээр хонио эрсээр байв. Яг тэр үед нэгэн чимээ сонсогдлоо.

Алдагдсан хонь Майй, майй...



58Page

Тайлбарлагч Хоньчин чимээ гарсан зүг рүү яаран гүйв. Тэнд алдагдсан хонь нь хясааны завсар хавчуулагдан гарч чадахгүй дааран чичэрч байлаа.

Хоньчин Энд байсан байхнээ. Их айсан уу? Одоо айх аюулгүй ээ. Би чамайг гаргаж авна. Тэгээд гэртээ харьцгаа.

Тайлбарлагч Хоньчин хонио аварч, мөрөн дээрээ тэгнэн гэрийн зүг яаран одов.

목자는 집에 와서 큰 목소리로 부인과 아이들에게 외쳤어요.



59Page



60Page

- Тайлбарлагч** Хоньчин гэртээ ирж чанга дуугаар эхнэр хүүхдүүддээ хандан чанга дуугаар
- Хоньчин** Олчихлоо. Алдагдсан нэг хонио олчихлоо. Хөршүүд ээ дуудан бүгдээрээ найр хийцгээе. хахаха
-
- Тайлбарлагч** Есүс хүмүүст хандан хэлэв.
- Есүс** Та нар ч бас алдагдсан нэг хонио олвол баярлана биз дээ? Нэг ч гэсэн хүн нүглээ гэмшиж Бурхан руу эргэвэл баярлах болно. Бурхан нэг ч хүнийг алдахыг хүсдэггүй.
- Тайлбарлагч** Есүс үргэлжлүүлэн
- Есүс** Сайн хоньчин өөрийнхөө хонин сүргийг мэддэг. Хонь ч бас өөрийнхөө хоньчны дууг таньж дагадаг. Танихгүй хүнийг харвал зугтдаг. Араатан амьтад хонь руу дайрвал сайн хоньчин тэднийг хамгаалж тулалддаг. Хоньчин хэзээ ч хонио хаяж зугтдаггүй.
- Тайлбарлагч** Есүс өөрийн хүмүүсийг хамгаалахын тулд тэдний төлөө амиа ч хайрлахгүй өгж чадна гэдгийг ийнхүү тайлбарлан өгүүлжээ.